

ГОВИЙН БҮСЭЭС ШИНЭЭР ИЛЭРСЭН ХАДНЫ СИЙЛМЭЛ ЗУРГИЙН ДҮРСГАЛ

Д.ХАТАНБААТАР

*ШУТИС, НТС, Түүх-Аялал жуулчлалын профессорын баг
e-mail: hb_parl@yahoo.com*

***ТҮЛХҮҮР ҮГ:** Өмнөговь, Ботго уул, Хадны зураг, янгир, хадны зургийн хувьсал, эрхлэх аж ахуй, хөгжил, өөрчлөлт*

***ТОВЧ АГУУЛГА:** Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Ботго ууланд буй цөөн тооны хадны сийлмэл зургуудыг шинээр судалгааны эргэлтэнд оруулж байна. Эдгээр зургууд нь хүрэл зэвсгийн үед холбогдох бололтой. Энд буй зонхилох дүрслэл болох “Янгир”-ын дүрслэлийг одоогоор бүх Монголын нутгаас илрээд буй бусад зургуудтай харьцуулан үзэхийн зэрэгцээ тэдгээрийн тархац, хөгжлийг тогтоож, түүгээр дамжуулан хадны зураг нь (Янгир) эртний хүмүүсийн аж ахуйн өөрчлөлт, хөгжлийн урт удаан хугацааны үйл явцыг тусган харуулсан хөдөлмөрийн үр дүн юм хэмээх дүгнэлтэд хүрлээ.*

МУИС-ийн Археологийн судалгааны баг 2008 оны зун Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Их өвгөн хэмээх газарт “Өмнөговийн элс” компанийн захиалгаар тус компаний лицензтэй талбайд археологийн хайгуул, малтлага судалгааг хийж, Монголын түүхийн олон үед холбогдох булш оршуулга, хадны сүг зураг сэлтийг шинээр илрүүлжээ. Тэдгээр дурсгалуудаас энэ удаад бид урьд өмнө судлаачдын хараанд өртөөгүй, шинээр олдсон хадны сийлмэл зургуудыг судалгааны эргэлтэнд оруулж байна. Номгон сумын нутаг, Их өвгөн уулын салбар болох Угалз, Гүн Хармагтай, Ботго болон зэргэлдээ орших Мөргөцөг зэрэг газарт хадны сийлмэл зураг тархсан байх ба тэдгээрээс төлөөлүүлж, энэхүү судалгаанд **Ботго** уулын дүрслэлийг сонгон авлаа. Ботго ууланд буй хадны сүг дүрслэлүүд нь ойр орчмын бусад сийлмэл зургуудтай үйлдсэн арга барил, сэдэв, дүр дүрслэлийн хувьд төстэй байгаа нь тэр орчмын (Угалз, Гүн Хармагтай, Мөргөцөгийн) хадны зургуудыг төлөөлүүлэн ойлгох боломжтой төдийгүй дээрх сүг зургууд нь нэгэн цаг үед үйлдэгджээ гэдэг урьдчилсан дүгнэлтийг өгч болохоор байв. Хожим эндээс илрүүлсэн бусад хадны зургийн судалгааг нэгтгэн хэвлүүлэх болно.

Энд хийгдсэн судалгаа тус хээрийн шинжилгээний ангийн тайланд (Түмэн нар 2008) тусгагдсанаас гадна тус уулын баруунтаа орших агуйн зосон зургийн талаар судалгааг нийтлүүлсэн байна (Анхсанаа 2008: 156-161). Үүнээс гадна уг

хээрийн шинжилгээний ангийн хүрээнд малтан шинжилсэн Их өвгөн 17-р булшны хэрэглэгдэхүүн археологич У.Эрдэнэбатын нэгэн сэдэвт зохиолд (Эрдэнэбат 2009) багтан оржээ.

Байршил: N 42°53'37.1", E 105°32'09.7" Өмнөговь аймгийн Номгон сумын төвөөс зүүн зүг 37 км-т Их өвгөн хэмээх цувраа хадан уул оршино. Ботго уул нь Их өвгөн уулын урд ганцаар сондгой орших шовх уул бөгөөд түүний оргил хэсэгт хадны сийлмэл зургууд тархжээ. Түүний хойд талын хэсэг өндөрлөг уулыг Угалз гэх бөгөөд ойр орчмын уулаар янгир олонтаа тохиолддог. Энд нийт 13 хэсэг газарт сийлэгдсэн зургуудыг баруунаас зүүн тийш нар зөв дугаарлан, хуулбарлан авлаа. Тус зургуудыг боржин чулуун хаднаа бүх биеийг хонхойлон сийлэх аргаар дүрсэлсэн ба цөөн тохиолдолд гадна тэгийг хөвөөлөн цохих аргыг ашиглан үйлджээ. Энд нийт 13 хэсэг газарт 27 сүг, дүрслэл сийлэн үлдээснийг тоймлон үзвэл:

- **Янгирын дүрслэл:** Том бага хэмжээгээр сийлсэн 23 янгирын дүрслэл байгаагийн дотор нэг янгирын толгой хэсгийг дутуу, эсвэл зөвхөн толгойн дүрслэл, мөн зөвхөн эврийг сийлэн үлдээжээ. Янгируудыг хэд хэдээр хажуу талаас нь дүрслэхдээ тайван явж буй байдалтай дүрсэлжээ. Ийм загвараар сийлэгдсэн янгир, буга, ан амьтдын дүрслэлийг судлаачид хүрэл зэвсгийн үед хамруулан үздэг.

- **Эвэр:** Янгирын зөвхөн толгой буюу эврийг дүрсэлсэн 2 зураг байна. Зөвхөн янгир төдийгүй бусад араатан амьтдыг толгой, эвэр зэрэг эрхтнээр нь төлөөлүүлэн дүрслэх дүрслэлийн арга олон хадны зурагнаа тохиолддог.

- **Үхэр:** Их биеийг харьцангуй том гэдэстэй, урт нарийн хүзүүтэй, хойд талын 2 хөлийг зөрүүлэн, урд хоёр хөлийг зэрэгцүүлэн, 2 чихийг ямар нэгэн зүйлд анхаарсан байдалтай, сүүлийг газарт шүргүүлэн эвэргүйгээр дүрсэлсэн байна. Биеийн ерөнхий төрхийг ажиглавал мухар үхэр бололтой.


- **Үл ойлгогдох дүрслэл:** Бэлчиж буй янгирын дунд 2 дугуй дүрсийг сийлсэн байх ба үүнийг судлаачид Нар, Сар, Од эрхэстэй холбон тайлбарласан байдаг. Гэхдээ нар сар хэмээн тайлбарлаж буй энэ дүрслэл олонхи тохиолдолд бүлэг амьтан, хүн, малын хажууд тохиолддог байна. Мөн дээрх дүрсийн хажууд крилл “Н” үсэгтэй төстэй дүрс буюу 2 хөндлөн зураасаар босоо зураасуудыг холбож, зүүн доод үзүүрийг гадагш эргүүлэн татсан юу болох нь үл ойлгогдох дүрслэл байна. Үүнтэй төстэй зураг Архангай аймгийн Тариат сумын Цагаан асгатын тохойн хаданд байдаг ба илийгээ хөхүүлж буй 7 буга, адуу үхэр, буган чулуун хөшөөнд тохиолддог бугануудын дунд сийлэгдсэн байжээ. Санжмятав энэхүү хадны зургийн он цагийг тогтоохдоо тамга, тэмдэгний дүрс бус адууны дүр дүрслэлд тулгуурлан хүрэл зэвсгээс эрт үед холбогдох бололтой хэмээжээ (Санжмятав 1995: 24)

Энд ан гөрөө, эсвэл дайн тулаан, сүсэг бишрэл, зан үйлийн холбогдолтой өгүүлэмж байхгүй ба янгирыг сүргээр нь эсвэл зөвхөн эвэр болон толгойг дүрслэн үзүүлсэн дүрслэл нь тухайн амьтныг төлөөлүүлэн зурсан хэрэг бололтой.

Монголын хадны зураг дахь “Янгир”, түүний эзлэмж

Зөвхөн Ботго уул төдийгүй Монгол нутгаас илрээд буй хадны зургийн үндсэн дүрслэлүүдийн нэгэнд янгирын өгүүлэмжтэй дүрс зүй ёсоор орох бөгөөд бараг бүх үеийн хадны зургуудад тохиолдох ажээ. Ботго ууланд дүрсэлсэнтэй адил хэв маягаар янгирыг дүрсэлсэн зургууд Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Арвижих (Дорж, Новгородова 1975: 33-35), Завсар уул (Новгородова 1984: 84), Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутаг Сэврэй уул (Гонгоржав, Энхбат 1997), Булган аймгийн Дашинчилэн сумын Арслант уул (Дорж, Новгородова 1975: 22-24), Говь-алтай аймгийн Бигэр сум, Бичигт хад, Увс аймгийн Сагил сум зүүн Турагийн тэрэм, Завхан аймаг Баянхайрхан сум Талын ухаа (Цэвээндорж 1982), Хад үзүүр (Цэвээндорж 1995), Өвөрмонголын Urad-ын төв хошууны Jigong Hailestai (Dalin Gurib 2000: 70) гэх мэт олон газруудад тохиолдох бөгөөд судлаачид гол төлөв хүрэл зэвсгийн үед холбогдуулан үзсэн байдаг. Ингэхдээ судлаачид янгирын хамтаар дүрслэгдсэн бусад содон дүрслэлүүдэд тулгуурлан он цагийг тогтоосон байдаг аж.

1977 онд биологич Д.Эрэгдэндава янгир болон янгир дүрсэлсэн хадны зургийн тархалтын талаар товч өгүүлэл нийтлэхдээ 150 орчим янгирын зурагтай газар буюу уулын систем, аймаг, сумын нэрийг дурьдан одоогийн гэрийн ямаа янгирас үүссэн байж болох тухай санал дэвшүүлсэн байдаг (Эрэгдэндава 1977: 159-198). Гэхдээ янгирын зургийн дүр дүрслэл, тоо хэмжээнд мөн л анхаарал хандуулаагүй ажээ.



Зураг 1. Монгол нутаг дахь хадны зураг дахь “Янгир”-ын тархац (тойм зураг)
 Өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрээс 170 гаруй газарт янгирын дүрслэл олж илрүүлсэн бөгөөд тэдгээрийг судлаачид Палеолит, Мезолит, Энеолит, Хүрэл, Хүннү, эртний Түрэг, Монголын эзэнт гүрний үед холбож үзсэн байх ба хамгийн их нь Хүрэл зэвсгийн үед тохиож байна.

Одоогоор хэвлэгдэн нийтлэгдээд буй хадны зургийн судалгааны бүтээлүүдэд янгирын дүрслэлийг дурьдсан нь 170 орчим болох ба тэдгээрийг нэгтгэн үзсэнээр Монголын хадны зургийн өгүүлэмжид янгирын дүрслэлийн эзлэх байр суурийн талаарх нэгдмэл ойлголтыг бий болгох боломжтой юм.

Хадны зурагт янгирын дүрслэл өнөөгийн Монгол нутгийн төв, баруун, өмнөд бүсийн хадтай, уулархаг нутгаар өргөн тархсан байх бөгөөд зүүн болон зүүн өмнөд бүсээр тохиолдохгүй байна (Зураг 1). Энэ нь тус бүс нутаг янгир идээшин нутаглахад тийм ч тохиромжтой бусаас гадна түүнийг сийлэн үлдээх хад чулуу хомс, тохиромжгүй байдагтай холбоотой бололтой.


Хадны зураг эртний хүмүүсийн аж ахуйн хөгжил өөрчлөлтийг ИЛТГЭХ НЬ

Эрхлэх аж ахуй түүнд зохицон төлөвшсөн соёл, сэтгэлгээний нөлөө хадны зураг дах дүрслэлүүдээс тодорхой харагддаг (Цэвээндорж 2009: 396). Эртний хүмүүс дүрслэх урлагийг сэдэн зосоор арслан заан, тэмээн хяруул, савгат хирс зэргийг хаданд зуран үлдээж эхэлснээс хойш хадны зургийн сэдэв, төрөл хэлбэр, арга барил хувьсан хөгжиж, хүрэл зэвсгийн үед ирэхдээ хамгийн дэвшилтэт бүрдлийг олжээ. Харин түүнээс нааш хадны зургийн дүрслэл, утга агуулга хумигдан багассан нь эртний анчин гөрөөчид нүүдэллэх хэв маяг буюу нүүдлийн мал аж ахуйд аажмаар шилжин орсон үйл явцыг тусган харуулж байж болох юм.

Энэхүү шилжилтийн үйл явц, аж ахуйн өөрчлөлтийг түүхэн бүх үеийн хадны зурагт тохиолддог янгирын дүрслэлийн тоо, давтамжаар тоймлон харуулах боломжтой юм хэмээн үзлээ. Үүний тулд хуучин чулуун зэвсгийн үеэс дундад эртний үе хүртэл хаданд сийлэгдэн зурагдсан янгирын дүрслэлийн тоо давтамж, дүрсэлсэн арга барилд бүдүүвчилсэн байдлаар харьцуулалт хийлээ (Зураг 2).

Түүхийн янз бүрийн үеүдэд янгирыг дүрслэх арга барил, хэв шинж бага ч атугай ялгаатай байгаа ба энэ талаар хожим тусгайлан бичих тул үл өгүүлэн харин янгирын дүрслэлийн тоо, хэмжээний тухай авч үзье. Түүхэн үеүүдээр харьцуулан харахад янгирын дүрслэлийн тоо, тохиолдох давтамж харилцан адилгүй байна. Янгирыг хуучин чулууны дээд үеэс анхлан хаднаа дүрсэлж эхэлсэн бөгөөд тоо давтамж, хэлбэр, дүрслэл нь он цаг наашлах тусам өргөжин, олширсоор улмаар хүрэл зэвсгийн үед оргилдоо хүрчээ. Хад чулуунаа янгирыг олон тоогоор дүрслэн үлдээсэн нь түүхэн тухайн үеийн Монгол нутагт оршин суугчдын эрхлэх аж ахуйг харуулж буй бөгөөд эртний нүүдэлчдийн ан агнуурын гол олз омог янгир байсныг тодорхойлж байна. Харин түүнээс нааш ийм зураг хаданд дүрслэх нь аажим багассаар дундад эртний үед дуусгавар болжээ.

Судлаач Ю.Болдбаатар эртний хүмүүс хаданд зураг, сүгийн зүйлсийг бүтээх болсон цаад шалтгааныг “Сүглэх ёс”-ны үүднээс тайлбарлан “...Сүглэх ёс нь хүмүүс ан агнуур голлон эрхэлж байсан эрт цагт (тухайлбал хүрэл зэвсгийн үед) газрын эзэн онгоны шүтлэгт шүтэлцэж тогтсон ёс заншил байгаад хожмын мал аж ахуй болоод хүмүүсийн оюуны хөгжлийн явцад эзлэмж нь багасаж зарим нэгэн зан үйлд хэлбэр төдий үлдэж, басхүү заримд нь орлуулах домын хэлбэрээр хувьсаж үлджээ...” (Болдбаатар 2005: 8) гээд мал аж ахуйн түүхэн хөгжилтэй холбоотойгоор сүглэх ёс нь орхигдсон хэмээн үзжээ.



Зураг 2. Түүхэн үеүд дэх “Янгир”-ын дүрслэл¹

Судлаачид нүүдлийн мал аж ахуй нь МЭӨ II мянганы сүүлийн хагас I мянганы эхээр Монгол нутагт ноёлох болсон талаар үндсэндээ санал нэг байдаг. Эрдэмтэн Г.Цэрэнханд нар нүүдлийн мал аж ахуйн хөгжил нь заримдаг, нүүдлийн болон сонгодог нүүдлийн мал аж ахуйн гэсэн гурван үе дамжсан ба нүүдлийн мал аж ахуй нь хүрэл зэвсгийн үед бүрэлдэж, дундад эртний үед сонгодог хэлбэрээ олсон гээд энэ нь зөвхөн малыг нүүдлийн аргаар адгуулах төдий бус түүний үзэл санаанд тулгуурласан оюуны ертөнц төлөвших болсныг өгүүлж буй хэрэг юм (Цэрэнханд нар 2006: 43) гэсэн нь бидний таамгийг батлахад дөхөм үзүүлнэ.

Үеэс үед янгирыг дүрслэх арга барил харьцангуй тогтвортой байсан хэдий ч түүнийг дүрслэх тоо, давтамж багасаж буй нь ан агнуурын аж ахуйгаас мал аж ахуйд шилжсэн шилжилт буюу амьжиргааны хэлбэрийн өөрчлөлттэй уялдан сүглэх зан үйл, хад, чулуун дээр зураг сүг үлдээх явдал багассантай холбоотой бололтой.

Эртний хүмүүс хуучин чулуун зэвсгийн үеэс хаднаа сүг зураг дүрслэн үлдээж эхэлсэн бөгөөд он цаг улирах тусам тэдгээр сүг зургийн тоо хэмжээ, утга агуулга нэмэгдсээр хүрэл зэвсгийн үед оргилдоо хүрч харин түүнээс хойш дүрслэл, тоо хэмжээний хувьд хумигдан багассаар дундад эртний үед хүрэхэд хад чулуун дээр сийлэх дүр дүрслэл нь бичээс, бичиг болон өөрчлөгдсөн байна.

Монгол нутгаас олдсон хадны зураг дахь янгирын дүрслэлд дулдуйдан эртний хүмүүс хүрэл зэвсгийн үед заримдаг мал аж ахуйгаас үйлдвэрлэх буюу нүүдлийн мал аж ахуйд аажмаар шилжин орж төгөлдөршсөн ба улмаар дундад

¹ Эдгээр янгирын зургууд нь тухайн хадны зургийн он цаг тогтоох шууд хэрэглэгдэхүүн болоогүй бөгөөд судлаачдын он цагийг нь тогтоосон хадны зургуудад дагалдах байдлаар дүрслэгдсэнийг анхаарна уу.

эртний үеийг хүрэхэд түүвэрлэх амь зуулга сонгодог нүүдлийн мал ахуйд бүрэн байр сууриа тавьж өгчээ гэж үзэж болох юм.

Ботго уул болон түүний ойр орчмын хадны зургууд нь бүгд нэгэн цаг үед үйлдэгдсэн бүлэг дурсгал бөгөөд бусад газарт сийлэгдсэн хүрэл зэвсгийн үеийн янгирын дүрслэлүүдтэй олон шинжээр адилсаж байгаа тул хүрэл зэвсгийн үед хамааруулан үзэж байна.

НОМ ЗҮЙ

- Анхсанаа Г.*, 2008. Өмнөговь аймгийн нутгаас олдсон хадны зосон зургийн шинэ дурсгал., МЖААЕ, Vol. 4, № 1 (312), х. 156-161.
- Болдбаатар Ю.*, 2005. Эртний нүүдэлчдийн соёлын зарим дурсгалын учир. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. Түүх. IV. № 245. х. 8
- Гонгоржав Г., Энхбат Г.*, 1997. “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” толь бичгийн хэрэглэгдэхүүн бүрдүүлэх дөрөв дэх экспедицийн өдрийн тэмдэглэл. СӨТ.
- Дорж Д., Новгородова Э.А.*, 1975. Петроглифы Монголии. т. 22, 24. УБ.
- Новгородова Э.А.*, 1984. Мир петроглифов Монголии. х. 84
- Санжмятав Т.*, 1995. Монголын хадны зураг. УБ.
- Түмэн Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д.*, 2008. Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан чулуутад ажилласан археологийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. МУИС-ийн Археологи-Антропологийн Тэнхмийн ГБСХ.
- Цогтбаатар Б., Гэрэлбадрах Ж.*, 1997. Бударын чулууны хадны зураг. SA. Tom. XVII, fasc. 5. УБ., х. 66-70.
- Цэвээндорж Д.*, 1982. Нүүдэлчдийн дурсгал судлах ангийн тайлан. ТХГБС.
- Цэвээндорж Д.*, 1983. Нүүдэлчдийн дурсгал судлах ангийн тайлан. ТХГБС.
- Цэвээндорж Д.*, 1995. Хад үзүүрийн зураг. SA. Tom. XV. Fasc. 1. УБ. х. 3-16
- Цэвээндорж Д.*, 2009. Монгол алтайн нурууны хадны зураг. Буурал түүхийн жимээр. Ред. Л.Лхагва, Ё.Баатарбилэг, УБ., МУЕТГ, х. 396.
- Цэрэнханд Г., Баяр Д., Өлзийбаяр С.*, 2006. Эрт дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл. УБ. х. 43
- Эрэгдэндагва Д.*, 1977. Янгир ба хадны зургийн тархалт. SA. Tom. VII. fasc. VII. УБ., х. 159-198.
- Эрдэнэбат У.*, 2009. Монгол нутагт загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс. УБ.
- NA. Dalin Gurib*, 2000. Inner Mongolia's art of rock carvings. **ӨМАХХ**. х. 70

РЕЗЮМЕ

Д.Хатанбаатар

Новые петроглифы найденные в Гобийской зоне

В данной статье мы приводим в научный оборот несколько новых петроглифов, найденные в Ботго уул, Номгон сум, Южногобийского аймака. Эти новые петроглифы принадлежат в бронзовой эпохе. Был сделан сравнительный анализ рисунков “Янгира” (горного козла) принадлежавших разным историческим периодам и найденных в разных местах Монголии и установлена определенная закономерность в их распространении и изображении. Был сделан вывод, что петроглиф “Янгир” (горного козла) достаточно четко показывает процесс развития хозяйственного уклада первобытного общества.


БОТГО УУЛЫН ХАДНЫ ЗУРГУУД



1. Янгирын дүрслэлүүд



2. Толгой болон эвэр дүрслэл



3. Үхэр болон үл ойлгогдох дүрслэл